



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 12 сарын 09 өдөр

Дугаар А/777

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 11/02 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Ховд аймгийн Жаргалант сумын төвлөрсөн хогийн цэгийн хэмжээг багасгах зорилгоор Замын сангийн хөрөнгө оруулалтаар “Төвлөрсөн хогийн цэгт хог отволдож дарж, зам гаргах зардал /Жаргалант сум/” ажлын хүрээнд 11, 12 дугаар сард зарцуулах зардалд 9 590 000 төгрөгийг зарцуулсугай.


2. Дээрх арга хэмжээнд зарцуулах 9 590 000 төгрөг /есөн сая таван зуун ерөн мянга/-ийг аймгийн Замын сангийн хөрөнгөөр 2020 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний жагсаалтын 4.9 дэх заалтаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баяхсүх/ нарт зөвшөөрсүгэй.

3. “Төвлөрсөн хогийн цэгт хог отволдож дарж, зам гаргах зардал /Жаргалант сум/ ажлын хүрээнд зарцуулах зардлыг хавсралтаар баталсугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-д даалгасугай.


ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ



Zax A/777 Ch
02 3590

Аймгийн Засаг даргын 2020 оны ...
дүгээр сарын –ны өдрийн ...
дугаар захирамжийн хавсралт



“Төвлөрсөн хогийн цэгт хог отволдож зарж, зам гаргах /Жаргалант сум/” ажлын
хүрээнд зарцуулах зардал

№	Зардлын төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ /60 хоног/	Нэг үнэ	төгрөгөөр
					Нийт үнэ
1	Хогийн цэгт ажиллах шатахууны зардал	л	3600	1800	6 480 000
2	Тос, масло, сэлбэг	багц	1	2 000 000	2 000 000
3	Хөдөлмөр хамгааллын зардал	Хүн/өдөр	60	6 000	360 000
4	Жолоочид урамшуулал, хоолны зардал	Хүн/өдөр	60	12 500	750 000
Нийт					9 590 000

-o o o-